



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2018.02.02 № А-1/350
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ЗАХИРАЛ, ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ

Албан даалгавар хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Авлигатай тэмцэх газраас Засгийн газарт 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 01/8836 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн зөвлөмжид туссан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, удирдлага менежментийг сайжруулах асуудлуудыг хангах зорилгоор дараах үүрэг даалгаврыг хүргүүлж байна. Үүнд:

1. Иргэд олон нийтийн дунд төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын талаарх бодит мэдээлэл дутмаг байдгаас үүдэн сөрөг ойлголтууд их байгаа тул компанийн засаглалыг сайжруулж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй түгээх тогтолцоог сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулж улирал бүр тайлагнах;
2. Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг нийт ажиллагсад, албан хаагчид, инженер техникийн ажилтнууд, олон нийтэд бий болгож, “Шилэн данс”-ны тухай хуулийг мөрдөн шилэн дансны цахим хуудсыг цаг хугацаанд нь тогтмол ажиллуулж хэвших;
3. Өнгөрсөн хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь харьяалагдах салбарын Төрийн захиргааны төв байгууллага болон дээд шатны төрийн захиргааны байгууллагын зарим зардлыг санхүүжүүлж ирсэн нь шалгалтаар илэрсэн байна. Иймд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага яам, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэх (суудлын автомашины зардал, томилолтын зардал, сургалт сурталчилгааны зардал болон бусад арга хэмжээний зардал гэх мэт)-ийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд хариуцлага тооцож, хохирлыг нөхөн төлүүлэх;
4. Компанийн захирал болон удирдах ажилтнууд гадаадад томилолтоор ажиллахдаа харьяа салбар яамны болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төлөөлөн удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авах;
5. Тухайн жилийн ажлын төлөвлөлт болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл, тооцоо судалгааг хангалтгүй хийж, бодит бус төлөвлөж хариуцлагагүй хандсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3-д төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэрэгшсэн байх ... гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, шаардлагад нийцсэн хүнийг томилж ажиллуулах талаар өгсөн удирдамж чиглэлийг биелүүлээгүй гүйцэтгэх удирдлагын контрактын гэрээг сунгахгүй болохыг анхаарах;

7.Санхүүгийн тайлан тэнцэлд өгсөн аудитын зөвлөмж, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтын тайланд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлт, төсөвт төвлөрүүлэх татвар, төрийн өмчийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй нөхцөлд захиралтай байгуулсан контрактын гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох, үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээг авах;

8.Гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнууд хамт олныг нэгдсэн удирдлагаар хангаж чадаагүйгээр байгууллагад хохирол учруулсан, байгууллагын зорилт эрх ашгийн төлөө шударгаар ажиллах эрх үүргээ хэрэгжүүлээгүй, хамт олны дотоод уур амьсгалыг эвдэж, үл ойлголцох байдал үүсгэсэн, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулсан нөхцөлд гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудад шууд хариуцлага тооцох заалтыг контрактын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэх;

9.Компанийн удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах талаар үр дүнтэй, оновчтой хэлбэрээр шинэлэг ажлыг зохион байгуулж, үр дүнд хүргэх, улирал бүр тайлагнах;

10.Компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт зэргийг үндэслэн тогтоох аргачлал боловсруулахад холбогдох саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх;

11.Өр, авлага болон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүг бууруулах талаар тодорхой хэмжээний арга хэмжээг үе шаттайгаар авах талаар санал боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх;

12.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй, ил тод зохион байгуулж худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх;

13.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрийн барааг импортын бараанаас тусад нь багцалж тендер зарлах, дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд авах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Тус албан даалгаврыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж, улирал бүр хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагуудад даалгаж байна.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР